

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ХАМТАРСАН БАГИЙН ГИШҮҮН

ТОВХИМОЛ

5

ЦАГДААГИЙН АЖИЛТНЫ ГАРЫН АВЛАГА



Хүүхдийг Ивээх Сан нь дэлхийн 120 оронд хүүхдийн эрхийн чиглэлээр ажилладаг төрийн бус, олон улсын байгууллага юм. Монгол Улсад 1994 оноос тогтвортой үйл ажиллагаа явуулж, Боловсрол, Хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн засаглал хөтөлбөрүүдийн хүрээнд үйлажиллагаагаа явуулж байна.

©Хүүхдийг Ивээх Сан, 2016 он

Боловсруулсан: П.Эрдэнэцэцэг, Г.Ариунтуяа
Хянан тохиолдуулсан: Х.Өлзийтунгалаг
Гарын авлагын зургийг Г.Ганбаяр

Хүүхдийг Ивээх Сан
Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
I дүгээр хороо, Аризона төв, 4-р давхар

Шуудангийн хайрцаг:
Төв шуудан, ш/х-1023, Улаанбаатар хот 13, Монгол Улс

Утас: +976-11-329365,
+976-11-329371

Факс: (976-11) 329361

И-Мейл: secretary@savethechildren.mn

Facebook: Save the Children in Mongolia

Twitter: Save the children MN

Вэб: www.savethechildren.mn

ЦАГДААГИЙН АЖИЛТНЫ ГАРЫН АВЛАГА

ХҮҮХДИЙН ЭСРЭГ ҮЙЛДЭГДЭЖ БҮЙ ХҮЧИРХИЙЛЛИЙН ТУХАЙ

Нийгмийн бүхий л орчинд хүүхдийн эсрэг дарамт, хүчирхийлэл түгээмэл байгаа бөгөөд хүүхэд цэцэрлэг, сургууль, хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллага болон гэр бүлийн орчинд хүчирхийлэлд илүү өртөж байна.

- Хүүхэд аливаа хэлбэрийн хүчирхийлэлд өртөх, садар самуун, доромжлол, басамжлал, гүтгэлэг, хүн худалдаалах зэрэг хууль бус үйлдэлд өртсөөр байна. Тухайлбал, 2–14 насны нийт хүүхдийн 46 хувь нь судалгаанаас өмнөх нэг сарын хугацаанд гэр бүлийн гишүүдийн зүгээс сэтгэл зүйн болон бие махбодын шийтгэлийг ямар нэгэн байдлаар амссан байна¹.
- Хоёр жилийн дотор бусдад зодуулснаас болж 5129 хүүхэд гэмтлийн эмнэлэгт ирж, эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна².
- Хөдөлмөр эрхэлж байгаа 5–17 насны хүүхдийн тоо өсөж буйн зэрэгцээ зарим тохиолдолд тэдний хөдөлмөрийн нөхцөл нь хүүхдийн эдийн засгийн аливаа мөлжлөг, тэвчишгүй хүнд хөдөлмөрөөс хамгаалуулах эрхийг зөрчиж байна³.
- Хөгжлийн бэрхшээлтэй 37000 хүүхдийн 46,6 хувь нь үе тэнгийнхэндээ шоолуулж дээрэлхүүлдэг⁴.
- Улсын хэмжээнд нийт халамж асрамжийн 34 төвд 998 хүүхэд амьдарч байгаагийн 60,0 хувь нь ядуугаас, 34,0 нь хүчирхийллийн улмаас гэр орноосоо дайжсан байна.
- Хүүхдэд чиглэсэн нийгмийн суурь үйлчилгээ (боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн гэх мэт)-ний хүртээмж муу, чанар хангалтгүй, эцэг, эхийн хариуцлага сул, амьдралын боломж доогуур байгаагаас хүүхэд осол, эндэгдэлд орох, эрх нь зөрчигдөх тохиолдол багагүй байна. Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнгээр судалгааны өмнөх 7 хоногийн хугацаанд 1 цагаас илүү хугацаагаар ганцааранг нь, эсвэл 10 хүртэлх насны өөр хүүхдэд харуулж гэрт нь үлдээсэн 5 хүртэлх насны хүүхдийн хувь 8, судалгааны өмнөх нэг жилд ямар нэгэн осол гэмтэлд өртсөн 2–14 насны хүүхдийн хувь 4 байгаа хүүхдийг эрсдэлтэй нөхцөл байдалд оруулж байна.
- Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнгээр 18 хүртэлх насны хүүхдүүдийн 16.6 хувь нь эцэг, эхгүй болон эцэг эхээсээ тусдаа амьдарч байна. Мөн түүнчлэн ямар нэгэн асран хамгаалагчгүй 15 хүртэлх насны 281 хүүхэд тоологдсоны дийлэнх буюу 228 хүүхэд нь хотод амьдарч байна.



¹ ҮСХ 2012 Хүүхэд хөгжил 4

² Хүүхдийн осол гэмтлийн өнөөгийн байдал судалгаа, 2007

³ ҮСХ (2012) Хүүхдийн хөдөлмөрийн судалгаа

⁴ Монгол дахь Хөгжлийн Бэрхшээлтэй Хүүхдийн эрхийн байдал судалгаа, ХБХЭЭХ, 2005

- Улаанбаатар хотын том, жижиг захууд, худалдааны төвүүдэд 1800 орчим хүүхэд хөдөлмөр эрхэлж байна. Эдгээрээс цар хүрээ, хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдийнхээ тоогоор хамгийн том нь Нарантуул зах байгаа бөгөөд 2007 оны байдлаар тус захад 450 орчим хөдөлмөр эрхлэгч хүүхэд бүртгэгдсэн талаар Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын үндэсний гурав ба дөрөвдүгээр тайлан илтгэлд дурджээ.
- Гэмт хэрэг үйлдэн ял эдэлж байгаа хүүхдүүдийн 22 хувь нь гэр бүлийн хүчирхийллээс, 42 хувь нь үе тэнгийнхний дарамтаас, 10 хувь нь сургууль дээрх таагүй харилцаанаас үүдэн гэмт хэрэг үйлдсэн гэж үзсэн байна. Тэд ял эдэлж байх явцдаа үе тэнгийнхэн, хорих байгууллагын ажилтнуудын зүгээс үйлдэгдэж буй хүчирхийлэл дарамтад өртөн нийгэмшүүлэх, нөхөн сэргээх мэргэжлийн үйлчилгээг хангалттай хүртэж чадахгүй, дахин өөр төрлийн гэмт хэрэг үйлдэж, ялаа нэмүүлэх тохиолдол нилээд гардаг байна. Мөн хорихоос суллагдсан ч нийгмийн амьдралд эргэн оруулах нөхөн сэргээх үйлчилгээ байхгүй, ажил сургууль олдохгүй, ялгаварлан гадуурхагдаж байна.
- Хүүхдийн эсрэг дарамт, хүчирхийллийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, мэдээлэх үйл явцад олон нийтийн оролцоо хангалтгүй байгаагаас хүүхэд амь насаа алдах, биедээ хүнд, хүндэвтэр бэртэл гэмтэл авах тохиолдол нилээдгүй байна.

Дээрх байдлаас харахад нийгмийн бүхий л орчинд хүүхдийн эсрэг дарамт, хүчирхийлэл, мөлжлөг, үл хайхрах хэлбэрүүд хэвийн үзэгдэл мэт оршиж, хүүхэд хамгааллын ээлтэй орчин бүрэлдэн, төлөвшиж чадаагүй байгаагаас хүүхэд гэрээсээ дайжих, хараа хяналтгүй болох, сургууль завсардах, хөдөлмөр эрхлэх, гэмт хэрэгт холбогдох, мансууруулах бодист донтох, амиа хорлох, хүн худалдах гэмт хэргийн золиос болох зэрэг сөрөг үр дагавар илэрч байна.

Гэр бүлийн хүчирхийллээс шалтгаалсан хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэргийн ойлголт, криминалистик шинж

Хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэл нь олон төрлийн хэлбэртэй. Гэр бүлийн хүрээнд үйлдэгдэж буй хүчирхийлэл, гэмт хэргийн хохирогч нь гол төлөв бага насны хүүхэд, эмэгтэйчүүд байдаг. Энэ төрлийн гэмт хэрэг нь гэр бүлийн хүрээнд үйлдэгддэг, хүчирхийлэлд өртөгч нь эдийн засгийн хувьд хүчирхийлэгчээс хараат, одоогийн болон ирээдүйн амьдрал нь түүнээс хамаарна гэдгийг хүчирхийлэгч байнга мэдрүүлдэг тул энэ төрлийн гэмт хэрэг нуугдмал, шалгагдсан тохиолдолд гэрч, хохирогчийн зүгээс үнэн зөв мэдүүлэг өгөхгүй, нотлох баримт хангалттай бус байдгаас хэргийг шалгахад хүндрэл, бэрхшээл гардаг. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд зааснаар хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг эцэг эх, асран хамгаалагч, гэр бүлийн бусад гишүүд хамгаалах үүрэгтэй гэж заасан ч манай орны хувьд хүмүүжүүлэх нэрээр зодож шийтгэх, хүнлэг бусаар харилцах, үл хайхрах, хөдөлмөр эрхлүүлэх явдал байсаар байна. Гэр бүл бол хүүхдийн хувьд хамгийн аюулгүй, амар тайван орчин байх ёстой билээ.

Гэр бүлийн хүрээнд үйлдэгдэж буй хүчирхийлэл нь өмнө нь иргэний маргаанд тооцогдож байсан бол одоо гэмт хэрэгт тооцогдох болсон. Иймээс цагдаагийн албан хаагч шинээр батлагдан гарсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг сайтар судалж, хуулийг хэрэглэх шаардлагатай.

Мөн энэ төрлийн гэмт хэргийг шалгахад нарийн арга тактик, төлөвлөгөө боловсруулах нь хэргийг түргэн шуурхай, бүрэн гүйцэд илрүүлж, шалгаж шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой. Үүний тулд цагдаагийн албан хаагч хамтарсан багийн гишүүдтэй хамтран асуудлыг ул суурьтайгаар, гэр бүлийн өргөн хүрээнд авч үзэж ажиллах шаардлагатай.

Манай улсын хувьд хүүхдийн эсрэг хүчирхийллийн шалтгаан, хүчин зүйлүүдийг доорх байдлаар тайлбарлаж болох юм. Үүнд:

1. Хүний эрх, хүүхдийн эрхийн талаарх олон нийтийн ойлголт, мэдлэг хангалтгүй байна. Нийгмийн сэтгэл зүйд хүүхдээ зодох, загнах, дорд үзэх явдлыг хүмүүжлийн арга хэмээн үзэх хандлага түгээмэл байна. Эцэг эхчүүд хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргуудыг мэдэхгүй, мэдсэн ч хэрэглэдэггүй, хүүхэдтэйгээ харилцах ур чадвар дутмаг байна.
2. Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, дарамт нь нийгэм дэх хүмүүсийн хоорондын тэгш бус байдал болон хүүхэд, насанд хүрэгчдийн хоорондын эрх мэдлийн тэнцвэртэй бус байдалтай холбоотой гэж мэргэжилтнүүд үздэг. Ихэнх тохиолдолд хүүхэд хүчирхийлэл үйлдэгчээс хараат буюу эсхүл түүнтэй харьцуулахад бага эрх мэдэлтэй байдаг байна.
3. Ядуурал, ажилгүйдэл, нийгмээс тусгаарлагдмал байдал, дасал болоогүй нөхцөлд амьдрах, шилжилт хөдөлгөөн зэрэг нийгмийн олон хүчин зүйлээс шалтгаалж байна. Жишээлбэл: Халамжийн төвд өсөж буй хүүхдүүд хүчирхийлэлд өртдөг тухай мэдээлэл их байдаг. Эдгээр хүүхдүүд гол төлөв нийгмийн эмзэг бүлгийн хүүхдүүд байдаг бөгөөд тэдний дотор нэн ядуу айлын, хөгжлийн бэрхшээлтэй, сургууль завсардсан гэх мэт хүүхдүүд байна.
4. Хүүхэд хамгааллын үйлчилгээний хоорондын уялдаа холбоо сул, тогтвортой байдал хангалттай биш байгаа нь эрсдэлд байгаа хүүхдэд хангалттай үйлчилгээ үзүүлж чадахгүй байна.



ХАМТАРСАН БАГААР АЖИЛЛАХ ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.1.1, 8.1.2, 8.3, 8.1.4, Хүүхдийн эрхийн тухай хууль болон Хүүхэд хамгааллын тухай хууль “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн 1.3.3 заалтууд хамтарсан багийн гишүүд тус бүрийн эрх, үүргийг томъёолсон.

Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 225 дугаар тогтоолоор батлагдсан “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-т хамтарсан багаар үйлчилгээ үзүүлэх ажлыг цаашид хөгжүүлэх, бэхжүүлэх талаар заасан нь энэ үйл ажиллагааг эрхлэн явуулах бүтэц, механизм, ажилтнуудыг бэлтгэх, сургах, дадлагажуулах ажлыг идэвхжүүлэх хэрэгцээг буй болгоод байна.

Мөн Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын код-202 (Гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл хүлээн авах), код-213 (Гэмт хэрэг, зөрчлийг шалгах хойшлуулшгүй ажиллагаа), код-227 (Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх), код-316 (Хүүхдийн эрхийг хангах), код-317 (Бэлэгсийн гэмт хэргийн насанд хүрээгүй хохирогчийн талаар авах арга хэмжээ), код-326 (Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх), код-511 (Гэрч, хохирогчийг хамгаалах), код-614 (Эцэг, эх нь хэн болох нь тогтоогдоогүй олдмол хүүхдийг бүртгэх)-ийг хэрэгжүүлж, үйл ажиллагаандаа баримтална.

Дээрх хууль, журмуудаас гадна Нийслэлийн Засаг даргын 2007 оны 04 дүгээр сарын 09-ны өдрийн “Нийслэлийн бүх хороодод хамтарсан баг байгуулан ажиллах тухай” 144 дүгээр Захирамжийг батлан гаргасан.

Уг Захирамжаар хорооны Засаг дарга, нийгмийн ажилтан, хэсгийн байцаагч, өрхийн эмч, сургуулийн нийгмийн ажилтан, хэсгийн ахлагч зэрэг албан тушаалтан, мэргэжилтнүүд гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, эрт шатанд нь илрүүлэх, шуурхай таслан зогсоох, нэгэнт өртсөн хүмүүст эрүүл мэнд, сэтгэл санааны хувьд хэвийн нөхцөл байдалд эргэн ороход нь дэмжлэг үзүүлэх зорилгоор нэгдэн ажиллах хамтарсан багийг Нийслэлийн бүх хороонд байгуулахаар заасан байна.

Хүүхэд хамгааллын хуулийн 4.1-д “хамтарсан баг” гэж гэр бүлийн болон бусад орчинд үйлдэгдсэн хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчил, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд хариу үйлчилгээ үзүүлэх анхан шатны нэгжийг, харин “хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ” гэж эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, нөхцөл байдлын үнэлгээ хийх, аюулгүй байдлыг хангах, дэмжих, холбон зуучлах, нийгмийн харилцаанд дасган зохицуулах, гэр бүлд нь эргэн нэгтгэх үе шат бүхий үйл ажиллагаа гэж заасан.



ХАМТАРСАН БАГТ ЦАГДААГИЙН АЖИЛТНЫ ҮҮРЭГ, ОРОЛЦОО

Монгол Улсын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт “Гэр бүлийн хүчирхийллийн тухай дуудлага, мэдээллийг хүчирхийлэл үйлдэгч, хохирогчийн байнгын буюу түр оршин сууж байгаа, эсхүл хүчирхийлэл үйлдэгдсэн газрын, хэрэв хохирогч эрүүл мэндийн байгууллага, хамгаалах байранд болон хүчирхийлэл үйлдэгч нь албадан сургалт явуулдаг байгууллагад байгаа бол уг байгууллагын оршин байгаа нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага хүлээн авч хуульд заасан арга хэмжээг авна” гэж заасны дагуу дуудлага мэдээлэл, хүсэлтийг хүлээн авна.

11 дүгээр зүйл. Мэдээлэл хүлээн авах, илрүүлэх, шалгах

- 11.1. Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийн талаар эсхүл эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар ирүүлсэн мэдээ, мэдээллийг нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтан, хууль сахиулагч хүлээн авч шалгах, эсхүл шаардлагатай арга хэмжээг хуульд заасны дагуу авна.
- 11.3. Хүүхдийн эрхийн зөрчлийн талаар ирүүлсэн мэдээ, мэдээлэл нь гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй бол хуульд заасан үндэслэл, журмын дагуу шалган шийдвэрлэх бөгөөд тухайн асуудлыг шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан нь хамтарсан баг, хүүхдийн эрхийн хууль зүйн хороо болон орон нутгийн хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн байгууллагад заавал мэдэгдэнэ.
- 11.4. Энэ зүйлд заасны дагуу ирүүлсэн мэдээ, мэдээллийг хүлээн авсан ажилтан, албан тушаалтан нь тухайн нөхцөл байдлыг газар дээр нь үнэлж, холбогдох тэмдэглэлийг нийгмийн ажилтан, хамтарсан багт хүргүүлнэ.
- 11.5. Хүүхдийн эрх зөрчсөн, эсхүл эрсдэлт нөхцөлд байгаа талаар мэдээ, мэдээллийг хүлээн авсан ажилтан, албан тушаалтан нь тухайн мэдээллийг газар дээр нь шалгах, үнэлэх явцад хүүхдийн амь нас, эрүүл мэндэд аюул шууд учирсан, эсхүл уг нөхцөл бүрдсэн, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийг түүнийг асран хамгаалах, харгалзан дэмжигч үйлдсэн, хүүхдийг тухайн орчинд үлдээх боломжгүй нөхцөл үүссэн бол яаралтай түр тусгаарлах арга хэмжээг эрх бүхий албан тушаалтанд тавьж, шийдвэрлүүлнэ.
- 11.6. Хүүхдийг түр тусгаарлах шийдвэр гарах хүртэл хугацаанд тухайн мэдээ, мэдээллийг хүлээн авсан нийгмийн ажилтан, албан тушаалтан нь хуульд заасан боломжит арга хэмжээг гэр бүлийн бусад гишүүд, хууль ёсны төлөөлөгчтэй зөвшилцөн хэрэгжүүлнэ.
- 11.7. Хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь тухайн хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэх үндэслэл байгаа бол энэ зүйлд заасан тусгаарлах арга хэмжээ авахдаа тэдний зөвшөөрлийг шаардахгүй.
- 11.8. Гэмт хэрэг, зөрчлийн шинжгүй боловч эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаарх мэдээ, мэдээллийг нийгмийн ажилтан дангаар болон багаар газар дээр нь, эсхүл байгаа орчинд нь очиж үзэх, харилцан ярилцах хэлбэрээр шалгаж болно.

11.9. Энэ хуульд заасны дагуу ирүүлсэн мэдээ, мэдээлэл нь хүүхдийн эрхийн эсрэг зөрчлийн шинжтэй бол хүүхдийн эрхийн ажилтан нь холбогдох хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

11.10. Хүүхдийн эрхийн эсрэг гэмт хэргийг цагдаагийн байгууллагын алба хаагч холбогдох хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

Монгол Улсын Хүүхэд хамгааллын тухай хуулиас...

Хүчирхийллийн улмаас албан ёсны тусламж дэмжлэг хүссэн мэдээллийн дагуу цагдаагийн байгууллага, цагдаагийн ажилтан хэргийг шуурхай таслан зогсоох, насанд хүрээгүй хохирогчийг хамгаалах арга хэмжээг нэн даруй авах үүрэгтэй бөгөөд болзошгүй хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, өртөгсдөд хуулиар олгогдсон эрх, үүргийнхээ дагуу тэдний эрх болон хэрэгцээнд суурилсан кейс менежмент хийх шаардлагатай.

Яаралтай хамгааллын үед болон хүүхдийн нөхцөл байдлыг сайжруулахад урт хугацааны, нарийн мэргэжлийн олон талт үйлчилгээ шаардлагатай үед кейс менежментийн үйлчилгээ нь хамгааллын үндсэн арга юм.

Хүүхэд хамгааллын салбар дахь кейс менежмент гэдэг нь хүүхдийн дээд ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор янз бүрийн мэргэжлийн хүмүүс хамтран үзүүлэх тусгай хамгаалалтын үйл ажиллагаа болон нийгмийн ажлын бүх арга барилыг нэгтгэсэн үр дүнд чиглэсэн цогц үйлчилгээ билээ⁵.

Ингэснээр хүчирхийлэлд өртсөн хохирогч хүүхдийн аюулгүй байдлыг хангахаас гадна хүчирхийлэл дахин давтагдахаас урьдчилан сэргийлэхэд зохих нөлөө үзүүлэх болно. Өөрөөр хэлбэл, хүчирхийлэл бүхий нөхцөлд байгаа хохирогчийг хамгаалах нь хүчирхийллийн эцсийн үр дагаврын нэг болох хохирогчийн амь нас, эрүүл мэнд, эрхтэн тогтолцооны бүрэн бүтэн байдал алдагдах, ойр дотны хүнийхээ гарт амь үрэгдэх явдлаас урьдчилан сэргийлэх асуудал юм.

Цагдаагийн байгууллагын ажилтан дуудлагын дагуу хэргийн газар ирж байгаа цагдаагийн ажилтан гомдол мэдээллийг шалган шийдвэрлэх, гэр бүлийн хүчирхийллийн болон бэлгийн хүчирхийллийн ялангуяа хүүхдийн эсрэг хүчирхийллийн асуудлыг шийдвэрлэхэд хамтарсан багт чухал үүрэгтэй.

⁵ Хүүхэд хамгааллын үндэс, С.Энхтуяа, ХИС, УБ 2009 он, 112-р хуудас

Хамтарсан багт ажиллаж буй цагдаагийн ажилтны үүрэг

1. Хүүхэд, гэр бүлийн эсрэг хүчирхийлэлтэй холбоотой мэдээлэл, гомдлыг хүлээн авч, бүртгэл мэдээллийг зохих журмын дагуу хөтөлж, нийгмийн ажилтантай мэдээллээ хуваалцах
2. Хүчирхийлэл үйлдэгдсэн газар дээр очиж тэмдэглэл хөтлөх, баримтжуулах шаардлагатай бусад ажиллагааг явуулах
3. Хохирогчид түүний эдлэх эрх болон хүчирхийлэл үйлдэгчид эрхийг нь хязгаарлах арга хэмжээ авахуулахаар шийдвэр гаргуулах журмын талаар тайлбарлан өгөх, захиргааны болон эрүүгийн хариуцлага ногдуулж болох тухай сануулах
4. Хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах арга хэмжээ авахуулах хүсэлтээ эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргах
5. Шаардлагатай тохиолдолд хохирогчийг эмнэлэгт эсвэл хамгаалах байранд хүргэх, боломжтой бол төрөл садангийн хүний түр хамгаалалтад өгөх, хохирогчийн гэр бүлийн бусад гишүүдийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авах
6. Шаардлагатай гэж үзвэл хүчирхийлэл үйлдэгчийг хууль тогтоомжийн дагуу захиргааны журмаар албадан саатуулах, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг хууль тогтоомжийн дагуу эрүүлжүүлэх байранд хүргэх
7. Гэмт хэрэг үйлдсэн болон үйлдэж болзошгүй, гэмт хэргийн хохирогч болсон хүүхэд, гэр бүлд хууль зүйн туслалцаа, зөвлөгөө өгөх
8. Хүүхэд, гэр бүлийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор холбогдох хуулиудыг олон нийтэд таниулах, сурталчлах
9. Хамтарсан багийн хуралдаанд оролцож, мэргэжлийн үнэлгээ дүгнэлтээ хуваалцах
10. Хорихоос суллагдсан, батлан даалтанд байгаа болон тэнсэн харгалзах ял авсан хүүхдүүдийг нийгэмшүүлэх нөхөн сэргээх үйлчилгээнд хамтран ажиллах саналыг хамтарсан багт гаргах
11. Хамтарсан багийн гишүүдэд хууль эрх зүйн талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх



Цагдаагийн ажилтан нөхцөл байдлыг тогтоон ажиллах нь

Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар (2014 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 247 дугаар тушаал) “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны журам” (код–326) шинэчлэгдэн батлагдсан. Уг журмаар цагдаагийн алба хаагч гэр бүлийн хүчирхийллийн болон хүчирхийлэлд өртсөн хүүхдийн дуудлага, мэдээллээр хэргийн газар очиж ажиллахдаа дараах нөхцөл байдлыг тогтоон ажиллах талаар үйл ажиллагааг нь журамлаж өгсөн. Үүнд:

- А. Гэр бүлийн байдал, ам бүлийн тоо, амьжиргааны түвшин, хэрвээ хохирогч насанд хүрээгүй хүн бол ямар сургуульд сурдаг эсэх гэх мэт
- Б. Хүчирхийлэл үйлдэгч тухайн байранд хохирогчтой хамт амьдардаг эсэх
- В. Хохирогч нь урд нь ийм гомдол гаргаж байсан эсэх
- Г. Хүчирхийлэл дахин үйлдэгдэхгүй гэсэн баталгаа гаргаж байсан эсэх
- Д. Гомдол гаргагчийн сэтгэл зүйн байдал
- Е. Гэмтэл бэртлээ нууж байгаа эсэх
- Ж. Нүдэнд үл харагдах гэмтэл бэртэл байгаа эсэх
- З. Хохирогч хүчирхийлэл үйлдсэн этгээдийг шалгуулахгүй эсвэл баривчлуулахгүй байхыг хүссэн, эсвэл гомдол гаргахаас айж байсан эсэх
- И. Гомдол гаргагч хүчирхийлэл үйлдсэн этгээдийг шийтгүүлэх талаар эргэлзэж байгаа эсэх
- К. Хүчирхийлэл нь цааш үргэлжилж болзошгүй байдал байгаа эсэхийг тогтоох талаар анхаарч ажиллах



Дээрх ажиллагаануудыг хийх явцад хохирогч өөрөө хүчирхийлэгчийг баривчлахыг хүсэхгүй байх, хохирогчийн өөрийн түүх, өмнө гаргаж байсан гомдлууд татгалзаж байсан, эвлэрч байсан байдал, хүчирхийлэгчийн дахин хүчирхийлэл гаргахгүй гэх мэт амлалт, нүдэнд ил харагдах гэмтэлгүй байх зэрэг хүчин зүйл нь гэмт хэргийн бүрэлдэхүүнд хамаарахаас бусад тохиолдолд цагдаагийн ажилтнаас холбогдох хууль болон үйл ажиллагааны журамд заасан үүргээ зохих ёсоор биелүүлэхэд нөлөөлөх ёсгүй.

Жич: Хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой мэдээлэл өгсөн хүн болон гэрч, хохирогчдод тусалцаа үзүүлсэн хүний талаарх мэдээллийг нууцлах ба ийм мэдээлэл өгсөн хүн, ажил үүргээ гүйцэтгэж байгаа албан тушаалтан, ажилтныг айлган сүрдүүлэх, заналхийлэхийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар хориглосон гэдгийг дахин сануулья.

Эдгээр ажиллагаануудыг хийж гүйцэтгэсний дараа дээрх бүх ажиллагааг тусгасан дэлгэрэнгүй илтгэх хуудас бичиж, бичгээр баримтжуулж, цагдаагийн бүртгэлд албан ёсоор оруулна.

Энэ нь давамгайлсан хүчирхийлэл үйлдэгчийг хэн болохыг тогтоох, хохирогчийн харилцааны бодит байдалд дүн шинжилгээ хийх, улмаар тухайн нөхцөл байдлын талаар үнэлгээг өгөх, орчны сөрөг нөлөө, аюулын түвшинг тогтоох суурь үндэс нь болно.

2016 оны 4 сарын 13-ны өдрийн А/42 тоот ХТҮГ-ын даргын тушаалаар Хүүхэд хамгааллын тухай хуультай холбогдуулан хүүхдэд үзүүлэх хариу үйлчилгээний маягт батлагдан гарсан. Энэхүү маягтад эрсдлийн үнэлгээ хийх, гэр бүлийн үнэлгээ хийх маягтууд багтсан бөгөөд цагдаагийн албан хаагч нь нийгмийн ажилтантай хамтран гэр бүлийн хүчирхийлэл ялангуяа хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй хүчирхийллийг үнэлж, үйлчилгээ үзүүлэхээр заагдсан.

! Цагдаагийн алба хаагч гэр бүлийн хүчирхийллийн болон хүчирхийлэлд өртсөн хүүхдийн дуудлагын дагуу очоод баримтжуулалт хангалттай хийлгүй эрүүлжүүлэх, хүчирхийлэгчийн сүүлийн гаргасан үйлдэлд арга хэмжээг зөвхөн баривчлах, торгох байдлаар хариуцлага тооцох, хохирогчийг хамгаалах, нийгмийн үйлчилгээнд холбон зуучлахгүй орхих нь хүчирхийллийн хохирогчид хүчирхийлэлтэй харилцаандаа үлдэх, хүчирхийлэл үргэлжлэх шалтгааны нэг болдог гэдгийг санаарай.

Гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийллийн хохирогч нь хүчирхийлэгчтэйгээ хэрэг шийдвэрлэгдтэл нэг орчинд амьдардаг, хамааралтай байдаг, хүчирхийлэгчийн зүгээс үзүүлэх ятгалга, амлалт, сүрдүүлэг, заналхийлэл, дарамт зэрэг нь олон нөхцөл байдлаас болж хохирогчийг гомдлоо буцахад хүргэдэг, хүчирхийлэл дахин давтагдан үйлдэгддэг гэдгийг анхаарах ёстой.

Хүүхэд, гэр бүлд урт удаан хугацааны хамгааллын үйлчилгээ үзүүлэхийн тулд цагдаагийн ажилтан хамтарсан багийн бусад гишүүдтэй ялангуяа нийгмийн ажилтантай хамтран ажиллаж ёстой.

Хойшлуулшгүй ажиллагаа, нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх ажиллагаа

Монгол Улсын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1 дэх заалтад “Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гомдол хүлээн авч, бүртгэх, хүчирхийлэл үйлдэгдсэн газар дээр хүрэлцэн очиж хохирогч, хүчирхийлэл үйлдэгч болон гэрчээс асууж, тэмдэглэл хөтлөх, шаардлагатай бусад ажиллагаа явуулах, 9.1.5 дахь заалтад “Шаардлагатай гэж үзвэл хүчирхийлэл үйлдэгчийг хууль тогтоомжийн дагуу захиргааны журмаар албадан саатуулах”, “Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг хууль тогтоомжийн дагуу эрүүлжүүлэх байранд хүргэх” зэрэг үүргийг хойшлуулашгүй ажиллагааны хүрээнд зохион байгуулахыг үүрэг болгосон.

! Хүчирхийлэл үйлдэгч нь согтууруулах ундаа хэрэглээгүй, эрүүл үедээ хүчирхийлэл үйлдэнэ гэдэг нь тухайн хүчирхийллийг бодсон, төлөвлөсөн, ухамсартайгаар үйлдэж байгаа гэдгийг анхаараарай.

Хүчирхийлэл үйлдэгдсэн бол аль болох хүчирхийлэл үйлдэгчийг хохирогчоос холдуулах хэрэгтэй байдаг. Заавал захиргааны журмаар албадан саатуулах биш хүчирхийлэл үйлдсэн бол гэмт хэрэг гэж үзэн, хэрэг үүсгэн шалгах ёстой.

Улмаар Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан “Таслан сэргийлэх арга хэмжээ”-г шууд авах болон Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн дагуу тодорхой арга хэмжээг авах хэрэгтэй.

Хүүхэд хамгааллын тухай хууль болон Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд цагдаагийн албан хаагч хамтарсан багт орж ажиллахаар заасан. Тус хуулиудад хамтарсан баг нь дараах ерөнхий үйлчилгээг үзүүлэхээр заасан.

- Хүүхэд, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, сургалт сурталчилгааны ажил зохион байгуулах;
- Хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, мэдээлэх, таслан зогсоох үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх, үйлчилгээ үзүүлэх;
- Нөхцөл байдлын үнэлгээн дээр тулгуурлан үйлчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэх;
- Хохирогчийг хамгаалах нөхөн сэргээх зорилгоор нийгмийн халамж үйлчилгээг үзүүлэх, холбон зуучлах;
- Үзүүлсэн үйлчилгээнийхээ талаар статистик мэдээллийг холбогдох байгууллагуудад хүргүүлэхээр заасан.



Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд хүүхдийн асуудлыг тусгайлан оруулсан бөгөөд гэр бүл дэх хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, гэр бүлийн бусад гишүүд хамгаалах үүргийг хүлээсэн.

Цагдаагийн албан хаагч мэдээллийг хүлээн авсан даруй холбогдох үйлчилгээ, туслалцаа дэмжлэгийг үзүүлэх арга хэмжээг зохион байгуулахаар заасан бөгөөд үйлчилгээг хамтарсан багийн бусад гишүүд, ялангуяа нийгмийн ажилтантай хамтран хүргэнэ.

ЭРСДЛИЙН ТҮВШИН БОЛОН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ ХИЙХ НЬ

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлд Эрсдэлт нөхцөлд байгаа, гэмт хэргийн хохирогч болсон, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, ял шийтгүүлж, албадлагын арга хэмжээ авагдсан, сургалт, хүмүүжлийн тусгай байгууллагаас суллагдсан хүүхдийг нийгэмд хэвийн амьдрахад нь тусалж, дэмжих чиглэлээр дараах хариу үйлчилгээ үзүүлнэ.

Үүнд мэдээлэл хүлээн авах, илрүүлэх, шалгах, нөхцөл байдлын үнэлгээ хийх, аюулгүй байдлыг хангах гэх мэтээр хариу үйлчилгээний дарааллыг зааж өгсөн.

Тэгвэл Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд ч нөхцөл байдлын үнэлгээг цагдаагийн албан хаагч хүчирхийлэл үйлдэгдсэн, үйлдэгдсэн байж болзошгүй орчинд очиж хийхээр заасан.

Хүүхдийн эрсдлийн нөхцөл байдлын үнэлгээг хийхдээ цагдаагийн албан хаагч нь нийгмийн ажилтантай хамтран хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний маягтын ХХ 03 буюу Хүүхдийн эрсдлийн нөхцөл байдлын үнэлгээний маягыг бөглөнө.

Үнэлгээгээр эрсдэл маш өндөр гэж гарвал шууд кейс нээж, шаардлагатай үйлчилгээг түргэн шуурхай хүргэх хэрэгтэй. Харин эрсдлийн үнэлгээгээр эрсдэлтэй гэж гарвал кейс нээн хамгааллын үйлчилгээг хамтарсан багаар үзүүлнэ. Эрсдлийн үнэлгээ болон гэр бүлийн нөхцөл байдал, хэрэгцээний үнэлгээг хамт хийгээд явах нь бодит амьдрал дээр цаг хугацаа хэмнэх, үйлчилгээг түргэн шуурхай хүргэхэд үр нөлөөтэй.



ХҮҮХЭД, ГЭР БҮЛД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭГ ҮЗҮҮЛЭХ НЬ

Цагдаагийн албан хаагч хамтарсан багийн гишүүдтэй хамтран эрсдлийн болон нөхцөл байдлын үнэлгээн дээр тулгуурлан үйлчилгээг төлөвлөн хүргэнэ. Үйлчилгээг хамтарсан багаар цогц байдлаар хүргэхэд хамтарсан багийн гишүүдийн тэгш оролцоо чухал. Үйлчилгээг үзүүлэхдээ кейс төлөвлөгөөний маягт буюу ХХ 05 маягыг ашиглан төлөвлөнө.

Цагдаагийн ажилтан хүчирхийлэлд өртсөн хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр дараах арга хэмжээг авна. Үүнд:

- Хүүхдийг хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээг үзүүлэх
- Нэг цэгийн үйлчилгээнд хамруулах
- Шаардлагатай тохиолдолд асрамж, халамжийн төвд шилжүүлэх
- Хүчирхийлэл үйлдэгчид эрх хязгаарлах арга хэмжээ авах
- Эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байгаа нөхцөлд хүчирхийлэл үйлдэгчид Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуульд зааснаар цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах

Хохирогч хүүхдийг хамгаалах, эрх зүйн туслалцаа үзүүлэх, шаардлагатай мэдээллээр хангах нь

Цагдаагийн албан хаагч нь хүчирхийлэлд өртсөн хохирогч хүүхдийн аюулгүй байдлыг хангаж ажиллах үед асуудлыг шийдвэрлэх явцад гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, тэднийг мэдээллээр хангах, дэмжлэг, туслалцаа үзүүлэх шаардлагатай.

Гэр бүлийн хүчирхийлэл болон хүүхэд хүчирхийлэлд өртсөн тохиолдолд мэдээлэл хүлээн авах, зөвлөгөө өгөх чиглэлээр Хүүхдийн тусламжийн утас 108, Улаанбаатар хотын цагдаагийн газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтсийн “Хохирогчийг түр хамгаалах байр”-ны 107 дугаарын утаснуудад хандахыг үйлчлүүлэгчдэд зөвлөнө.

Хүүхдийн оролцоог хангах нь

Цагдаагийн албан хаагч хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй өндөр эрсдэлтэй хүүхэдтэй ажиллахдаа хүүхдийн саналыг харгалзан үйлчилгээг төлөвлөн хэрэгжүүлнэ. Ялангуяа хүүхэд 7-оос дээш настай бол заавал асуух ёстой. Энэ нь Хүүхдийн эрхийн тухай хууль болон Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар олгогдсон эрх.



ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙГ ХҮЧИРХИЙЛЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ

Цагдаагийн албан хаагч нь хамтарсан багийн бусад гишүүдтэй хамтран гэр бүлийн хүчирхийлэл болон хүүхдийн эсрэг хүчирхийллийн тухай болон хүний эрхийн талаарх олон нийтийн ойлголт хандлагыг нэмэгдүүлэх, гэр бүлийн хүчирхийллийн мөн чанар, хор хөнөөлийг таниулах, хүний эрх, эрх чөлөө, эрх тэгш байдлыг хүндэтгэсэн, гэр бүлийн тэнцвэрт харилцааг дэмжсэн эерэг зан үйл, хандлагыг нийгэмд төлөвшүүлэх шаардлагатай байна.

Хамтарсан багаар хүний эрх, хүүхдийн эрхийн талаарх сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулах нь дараах ач холбогдолтой. Үүнд:

- Иргэд, олон нийтийн хүний эрхийн боловсрол нэмэгдэх
- Хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийг байдаг л зүйл, хэвийн гэж ойлгохоо болих
- Хүчирхийлэл гарсан үед мэдээлдэг, мэдээлэх үүргээ биелүүлдэг болох
- Хүний эрхийн талаар мэдлэгтэй болох
- Хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийг бууруулна гэх мэт.

Хүүхдийн эсрэг болон гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, өртсөн тохиолдолд үйлчилгээ үзүүлэх, хамгаалах нь дан ганц цагдаагийн байгууллагын ажил биш, хамтын үйл ажиллагаа гэдгийг цагдаагийн албан хаагч ойлгож, хамтарсан багийн идэвхитэй гишүүн байх хэрэгтэй.

Хүчирхийлэл гарахаас өмнө зогсоох, нэгэнт гарсан хүчирхийллийн сөрөг үр дагаврыг бууруулах, дахин гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхийн зэрэгцээ хүчирхийлэл үйлдэгдэх өндөр магадлалтай, эрсдэлтэй гэр бүлд чиглэсэн урьдчилан сэргийлэх нэг бүрчилсэн арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх нь цагдаагийн ажилтны нэн тэргүүний ажил гэдгийг анхаарах шаардлагатай.

Гэр бүл хүчирхийллийн талаар олон нийтийн хандлагыг өөрчлөн энэ талаарх ойлголтыг нэмэгдүүлэхэд мэдээллийн хэрэгсэл их чухал. Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл гэдэгт зурагт, радио, сонин, сэтгүүл, интернэт ордог. Эдгээрийг ашиглан нийгмийн сайн сайхны төлөө, хүн амд эрүүл зан үйл төлөвшүүлэх, боловсрол олгоход зориулсан үйл ажиллагааг сурталчлах нь үр дүнтэй.

Хүүхэд залуучууд, багш нар, эцэг эх асран хамгаалагч хүүхдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх дараах аргыг санал болгож байна.

Гэр бүлийн хүрээнд:

- Согтууруулах ундаа хэрэглэхийг хориглох
- Хүүхэд хүмүүжлийн эерэг аргад суралцах
- Гэр бүлийн салалтаас зайлсхийх
- Хүүхдээ хүндэлж харилцах
- Эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан хүүхдийг хэрхэн хүмүүжүүлэх, тэдэнтэй хэрхэн ярилцах талаар үе шаттай сургалтуудыг явуулах
- Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг тэмцэх

Сургуулийн орчинд:

- Ерөнхий боловсролын сурган хүмүүжүүлэгч, багш ажилтнуудыг хүүхэдтэй хэрхэн харилцах, хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргуудад үе шаттай сургах
- Нийгмийн ажилтнууд хүүхэд бүрт хүрч ажиллах
- Хүүхдийн байгууллага, сургуулиуд хүүхдийн хүчирхийллийн эсрэг үйл ажиллагаа явуулах
- Хэвлэл мэдээллийн хэрэгслээр явуулж буй мэдээлэлд хяналт тавих

Санхүүжилт

Хүүхдийг хүчирхийлэлд өртөх явдлаас урьдчилан сэргийлэхийн тулд энэхүү ажилд тодорхой хөрөнгө, санхүүжилтийг төсөвлөх талаар хуульд заагдсан. Тухайлбал, Хүүхэд хамгааллын тухай хуульд хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай зардлыг төсөвт суулгахыг хуульчлан өгсөн. Тиймээс хуулийг хэрэглээ болгох шаардлагатай байна.

Мөн Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулинд гэр бүлийн хүчирхийллийн хохирогч болон хүүхдэд үйлчилгээ үзүүлэх, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай үйл ажиллагааны зардлыг жил бүрийн улсын төсөвт суулгаж батлахаар заасан.

23 дүгээр зүйл. Хүүхэд хамгааллын санхүүжилт

23.1. Хүүхэд хамгааллын үйлчилгээний төсвийг улсын төсөвт тусгаж санхүүжүүлнэ.

23.2. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга нь хүүхэд хамгааллын тогтолцоог бүрдүүлэх зорилгоор хүүхэд хамгааллын хамтарсан баг, хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны ажил, үйлчилгээний зардал, нийгмийн ажилтны урамшууллыг улс болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлнэ.

Хүүхэд хамгааллын тухай хуулиас

Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх байгууллагуудын чиг үүрэг, уялдаа холбоо нь Монгол Улсын Засгийн газрын тухай, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон бусад хууль тогтоомжоор зохицуулагдсан салбар дундын бүтэцтэй байна.

НОМЗҮЙ

- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд цагдаагийн ажилтны үйл ажиллагаа (2015) УБ.
- ХХХТ (2010). Хүүхдийг хүчирхийллээс хамгаалах гарын авлага.УБ.
- ЦЕГ (2007). Жендэрээс үүдэлтэй хүчирхийллийн Монгол дахь төлөв байдлын эмхтгэл” 42 дахь тал, УБ,
- ЯХИС (2011). Хамтарсан багаар хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх нь. УБ.

Зөвлөмж боловсруулахад санал өгсөн цагдаагийн байгууллагын ажилтнууд:

- Цагдаагийн ерөнхий газрын Гэмт хэрэгтэй тэмцэх газрын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа Г.Арсланхуяг
- Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтсийн 7 дугаар хорооны хэсгийн байцаагч, цагдаагийн дэслэгч Н.Мөнхгэрэл
- Чингэлтэй дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтсийн 4 дүгээр хорооны хэсгийн байцаагч, цагдаагийн ахлах дэслэгч Б.Баттулга
- Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн 3 дугаар хэлтсийн хэсгийн байцаагч, цагдаагийн дэслэгч Х.Баасанхүү



Хүүхэд хамгааллын тогтолцооны загварыг (хүүхэд хамгааллын хамтарсан багийг) анхан шатны нэгжид (нийслэл, дүүрэг хороонд, орон нутаг сум, багт) бэхжүүлэх зорилгоор Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 23, 27-р хороо, Сонгинохайрхан дүүргийн 2,10-р хороо, Чингэлтэй дүүргийн 9,10-р хороо болон Архангай аймгийн Хайрхан, Батцэнгэл сум, Эрдэнэбулган сумын 4-р багийг сонгон хэрэгжүүлж байна. Тус төсөл нь 2015- 2018 оны хооронд ЖАЙКА-гийн санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгжих юм.

Төслийн хүрээнд дараах үйл ажиллагааг явуулна:

Үйл ажиллагаа 1: Хүүхэд хамгааллын хамтарсан багийн гишүүдийн чадавхийг бэхжүүлэх

Үйл ажиллагаа 2: Хүүхэд хамгааллын хамтарсан багийн гишүүдийн болон салбар дундын байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах

Үйл ажиллагаа 3: Олон нийтийн дунд хүүхэд хамгааллын талаарх ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх

Үйл ажиллагаа 4: Төслийн хүрээнд хийгдсэн үйл ажиллагааны сургамж, хүрсэн амжилт, үр дүнд үндэслэн холбогдох яамдад нөлөөлөх

Төслөөс хүлээж буй үр дүн:

- Хамтарсан багийн гишүүд нь мэргэжлийн ур чадвар болон хүүхэд хамгааллын үйлчилгээний арга зүйн мэдлэгээ сайжруулж, зорилтот орон нутаг дахь хүүхдүүдэд хамтарсан багаар хамгааллын үйлчилгээг үзүүлэх боломжтой болсон байна.
- Хүүхэд хамгааллын тогтолцооны хүрээнд байгууллага хоорондын уялдаа холбоо зохицуулалтыг хангах механизм бий болж, бэхжиж хүүхдийн эсрэг хүчирхийллийг эрт илрүүлж, урьдчилан сэргийлэхээс гадна зорилтот орон нутагт хүүхдийн эсрэг хүчирхийллийн эсрэг хариу арга хэмжээг цаг алдалгүй хүргэх боломж нэмэгдэнэ.
- Хүчирхийлэлд өртөх өндөр эрсдэлтэй хүүхдүүд ба тэдний эцэг эх, асран хамгаалагчдын хоорондын харилцааг сайжруулахад дэмжих, хүмүүжлийн эерэг аргыг түгээн дэлгэрүүлнэ.
- Үндэсний болон орон нутгийн түвшин дэх төрийн байгууллагуудын зүгээс хүүхэд хамгааллын үйлчилгээнд ач холбогдол өгч ажиллах нь нэмэгдсэн байна.